



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/105

Зуунмод сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар үйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх “Аялал жуулчлалын бүс, байгаль, түүх,соёлын өв бүхий газарт отоглох цэг, авто машины зогсоол, ариун цэврийн байгууламж барих” ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үнэлгээний хорооны дарга:

А. Зоригоо (Худалдан авах ажиллагааны албаны дарга)

Гишүүдэд:

Б.Батбаяр (ГХБХГазрын удирдлагын хэлтсийн дарга)

А.Батзаяа (Аймгийн ИТХурлын ажлын албаны мэргэжилтэн)

Д.Дашдаваа (Иргэний төлөөлөл), (Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

Г.Ундармаа (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2. “Аялал жуулчлалын бүс, байгаль, түүх,соёлын өв бүхий газарт отоглох цэг, авто машины зогсоол, ариун цэврийн байгууламж барих” ажлын гүйцэтгэгч сонгох ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (А.Зоригоо)-д, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ Захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлэлж ажиллахыг Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР



4192010323